



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/191

Есөнбулаг

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.1 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамщууллын журам" А/254 дүгээр тушаалаар баталсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Есөнбулаг сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороо дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга Я.Жаргалцэцэг (Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Г.Булган (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)

Ш.Батзүсэм (иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

А.Бямбадорж (иргэний төлөөлөл)
(тохиролцсон)

Нарийн бичиг:

Б.Эрхбаяр (Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Я.Жаргалцэцэг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

